



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/101/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дорноговь аймаг, Сайншанд сум  
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 99092469      Цахим хаяг: .....  
Аудитын менежер: Э.Энхцэцэг  
Утас: 90077079      Цахим хаяг: .....  
Аудитор:              Г.Энхтөр  
Утас: 96441690      Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III багц, Утас: (705) 2-27-34	<b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ХАШЦЭЦЭГ ТАНАА</b>
<u>2019.02.26</u> № <u>1-6/224</u>	
танай _____ -ны № _____ -Т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч С.Хашцэцэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 23-наас 2019 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэг нь Хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхэд бүрийг асрах , хамгаалах , хөгжүүлэх , сургуульд элсэхэд бэлтгэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох стандарт, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлын материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвөөс зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 188,426.3 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 422.87 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	856.60	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	165.70	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	1,022.30	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал**

2018 оны 1 дүгээр сард 31734 төгрөгийн , 3 дугаар сард 10127 төгрөгийн , 12 дугаар сард 88598 төгрөгийн илүү цагийн хөлс , 12 дугаар сард 35226 төгрөгийн үндсэн цалинг үндэслэлгүйгээр илүү бодож олгосон байна.

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Батлагдсан төсөв , Хамтын гэрээ тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 185,750.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 184,402.0 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь төсөв 1,347.9 мянган төгрөгөөр хэмнэгдэхэд шалтгаалжээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өглөгийн үлдэгдэл 339578 төгрөг , авлагын үлдэгдэл 517069 төгрөг тус тус байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

#### 3.1.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өглөгийн үлдэгдэл 339578 төгрөг , авлагын үлдэгдэл 517069 төгрөг тус тус байна

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Авлага , өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 , 39.4.2 , 45.2 заалтуудыг мөрдөж ажиллах

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

## **4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

---

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,008,781.95	41,870,024.55
27	АВЛАГА	519,370.00	517,069.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	405,000.00	-
34	Бусад авлага	114,370.00	517,069.00
35	Байгууллагаас авах авлага	69,370.00	517,069.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	45,000.00	-
60	БАРАА МАТЕРИАЛ	32,489,411.95	41,352,955.55
61	Түүхий эд материал	5,946,306.73	8,202,246.73
62	Тусгай зориулалттай материал	5,905,556.73	8,202,246.73
63	Эм боох материал	40,750.00	-
66	Хангамжийн материал	26,543,105.22	33,150,708.82
67	Бичиг хэргийн материал	1,614,085.00	2,484,555.00
68	Аж ахуйн материал	18,800,027.82	25,634,272.82
70	Түлш шатах тослох материал	3,036,000.00	3,599,500.00
71	Барилгын засварын материал	-	157,850.00
72	Хүнсний материал	3,092,992.40	1,274,531.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	427,539,045.42	454,503,537.14
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	427,539,045.42	454,503,537.14
108	Биет хөрөнгө	427,571,857.89	448,110,349.61
109	Барилга, байгууламж	434,230,900.00	415,641,302.00
110	Хуримтлагдсан эзэгдэл	(46,147,858.84)	-
113	Машин, тоног төхөөрөмж	38,107,998.45	33,297,075.45
114	Хуримтлагдсан эзэгдэл	(31,295,740.92)	(27,082,366.50)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,351,076.40	23,674,001.40
116	Хуримтлагдсан эзэгдэл	(11,484,459.54)	(11,624,460.03)
122	Бусад үндсэн хөрөнгө	26,999,106.00	22,822,406.00
123	Хуримтлагдсан эзэгдэл	(7,205,830.26)	(8,634,275.31)
125	Номын фонд	16,666.60	16,666.60
126	Биет бус хөрөнгө	(32,812.47)	6,393,187.53
127	Програм хангамж	175,000.00	175,000.00
128	Хасагдуулга	(207,812.47)	(207,812.47)
129	Галар эзэмших эрх	-	6,426,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	460,547,827.37	496,373,561.69
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,002,045.00	339,578.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,002,045.00	339,578.00
164	Өглөг	1,002,045.00	339,578.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	955,045.00	238,698.00
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	100,880.00
170	Бусад өглөг	47,000.00	0.00
171	Байгууллагад төлөх өглөг	44,000.00	0.00
172	Хувь хүмүүст төлөх өглөг	3,000.00	0.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	459,545,782.37	496,033,983.69
215	Засгийн газрын хувь оролцоо	459,545,782.37	496,033,983.69
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСын/ орон нутгийн сан	58,846,837.28	65,272,837.28
217	Өмч: -Төрийн өмч	58,846,837.28	65,272,837.28
223	Хуримтлагдсан үр дүн	384,440,787.54	359,895,923.00
224	Өмнөх үеийн үр дүн	384,440,787.54	384,453,764.62
225	Тайлант үеийн үр дүн	-	(24,557,841.62)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,258,157.55	70,865,223.41
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	460,547,827.37	496,373,561.69

4417144353  
EIOA0056 9025707

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	131,273,300.00	186,878,185.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,128,185.00
77	Нийтлэг татварын бус орлого	-	1,128,185.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,128,185.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	800,000.00
87	Эзэмийн хүүгийн орлого	-	328,185.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,273,300.00	185,750,000.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	131,273,300.00	185,750,000.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	131,273,300.00	185,750,000.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	119,046,936.36	188,426,321.03
148	УРСГАЛ ЗАРДАЛ	119,046,936.36	188,380,071.18
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,395,936.36	165,029,718.98
150	Цалин, хэс болон нэмэгдэл урамшил	72,168,829.00	107,731,411.00
151	Цалин	63,001,658.00	95,094,361.00
152	Нэмэгдэл цалин	5,341,021.00	3,324,009.00
153	Унаа хоолны хангамалт	-	2,824,600.00
154	Урамшуулал	3,826,150.00	6,488,441.00
157	Ажил олгогчоос нийгэмийн даатгалд төлөх шимтгэл	8,190,737.00	13,011,441.00
158	Тэтгэрийн даатгалын шимтгэл	5,212,285.00	11,436,363.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	744,612.00	371,427.00
160	УОМШ өмчийн даатгалын шимтгэл	595,688.00	711,868.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	148,921.00	75,920.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,489,231.00	815,863.00
164	Байр шингэлтэй холбоотой тогтмол зардал	7,264,578.00	11,373,738.00
165	Гэрэл шалгалтны зардал	1,800,494.00	2,141,138.00
166	Тули, халаалтын зардал	3,843,684.00	6,936,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,620,400.00	2,296,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	2,468,220.00	3,644,840.00
171	Бичиг хэргийн материал	218,500.00	810,030.00
172	Тээвэр, шатахууны зардал	551,400.00	1,210,020.00
175	Хөг хавгалал устгах, цэвэрлэх	1,650.00	120,000.00
176	Бага үнэ тургэн элэгдэл зүйлс	1,696,670.00	1,504,790.00
181	Норматив зардал	10,175,564.00	14,244,193.20
182	Эм	73,250.00	150,750.00
183	Хөөл	10,102,314.00	14,093,443.20
185	Эз хогшил, урсгал зөвшөөрн зардал	138,000.00	1,850,000.00
189	Урсгал зөвшөөр	138,000.00	1,850,000.00
190	Төмбөлт, лочны зардал	70,000.00	126,000.00
192	Дотоод төмөрлөлийн зардал	70,000.00	126,000.00
194	Бусдаар гүйцэтгүүдсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	275,300.00	297,500.00
195	Бусдаар гүйцэтгүүдсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,400.00	177,500.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэгээ тогтоох зардал	25,900.00	120,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	14,644,708.36	12,750,595.78
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн даалганы зардал	-	535,000.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хориголд	14,644,708.36	12,215,595.78
219	ТАГААС	-	1,347,952.20
220	Төрийн өмчит байгууллагад олгох тагаас	-	1,347,952.20
221	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,347,952.20
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,651,000.00	22,002,400.00
228	Бусад урсгал шилжүүлэг	3,651,000.00	22,002,400.00
234	Тэтгэвэрт гарвалд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,902,400.00
235	Хөдөө ОН-г төгсгөл суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх тэтгэмж	3,651,000.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамжуулалт	-	100,000.00
253	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	46,249.85
254	Дотоод эх үүсвэрээр	-	46,249.85
257	Тонг төхөөрөмж	-	46,249.85
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	12,226,363.64	(1,548,136.03)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	23,009,705.59
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гэрл	-	3,378,438.49
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	19,635,267.10
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)	-	(23,009,705.59)
288	НИЙТ ҮР ДҮН (VII-III+VI)	12,226,363.64	(24,657,841.62)

4417144353  
EHOA0056 9025701

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮДЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	131,273,300.00	185,750,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,273,300.00	185,750,000.00
111	Улсын зинвэрсон төсвөөс	131,273,300.00	185,750,000.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	131,273,300.00	185,750,000.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЭЗЭЛДИЙН ДҮН (II)	96,049,040.00	185,750,000.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	96,049,040.00	185,750,000.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,308,040.00	162,399,647.80
150	Цалин, хөлө болон нэмэгдэл урамшил	72,374,499.00	108,033,927.60
151	Үндсэн цалин	62,895,691.00	93,149,595.00
152	Нэмэгдэл	4,817,339.00	4,810,053.00
153	Уриа хосны хангамалт	-	2,824,600.00
154	Үр дүнгийн урамшуулал	4,661,469.00	7,249,679.00
157	Ажил олгохоос нийгмийн даатгалд татан шимтгэл	7,990,667.00	13,461,441.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,380,304.00	12,709,434.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	402,490.00	160,502.00
160	УОМШ өмчийн даатгалын шимтгэл	322,052.00	177,901.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	80,738.00	37,600.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	805,083.00	376,004.00
164	Байр шингэлтэй холбоотой төгсгөл зардал	4,326,094.00	12,162,138.00
165	Гэрэл шонгионы зардал	2,654,094.00	2,391,138.00
166	Түлш, халамгийн зардал	-	7,475,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,672,000.00	2,296,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	956,685.00	6,047,890.00
171	Бичиг хэрэг	13,500.00	394,500.00
172	Тэжээл, шатаауун	351,400.00	1,235,120.00
174	Нөм, хмэлэл	100,000.00	-
176	Бая үнэтэй, гургин зогсоох, ахуйн га зүйлс	291,785.00	4,418,270.00
181	Нормативт зардал	6,228,695.00	14,008,901.80
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00	110,000.00
183	Хөөл, хүнс	6,178,695.00	12,168,901.80
184	Нормын сувцас, шилэн далаа	-	1,730,000.00
185	Эд хосина, урсгал засварын зардал	138,000.00	3,308,850.00
186	Багаж техник хэрэгсэл	-	440,000.00
187	Тавилга	-	750,000.00
189	Урсгал засвар	138,000.00	2,118,850.00
190	Томилгоот, лочны зардал	59,000.00	112,000.00
192	Дотоод албан томилгоот	59,000.00	112,000.00
194	Бусадар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249,400.00	394,500.00
195	Бусадар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	249,400.00	274,500.00
196	Аудит, баталгаажуулалт, зөргөлдл төгсгөл	-	120,000.00
208	Бариан үйлчилгээний бусад зардал	75,000.00	4,870,000.00
210	Хичээл үйлдвэрлэлийн ажилт аидх	75,000.00	4,870,000.00
221	УРСГАЛ ШИНЖҮҮЛЭГ	3,651,000.00	23,350,352.20
225	Бусад урсгал шилжүүлэг	3,651,000.00	22,002,400.00
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,902,400.00
232	Хөдөө орон нутагт төлбөртэй ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	3,651,000.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шалгал урамшуулал	-	100,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,347,952.20
237	Төлбөрүүлэх шилжүүлэг	-	1,347,952.20
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	35,224,260.00	-
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	35,224,260.00	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хэний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсхийн үлдэгдэл	35,224,260.00	-

4417144353  
EBCA0056 9028797

АУДИТ ХИЙГДСЭН ИЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,846,837.28	16,258,157.55	400,238,714.61	416,496,872.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			32,812.47	32,812.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,846,837.28	16,258,157.55	400,271,527.08	416,529,684.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайланг үеийн үр дүн			5,870,436.46	5,870,436.46
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,846,837.28	16,258,157.55	384,440,787.54	400,698,945.09
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,846,837.28	16,258,157.55	384,440,787.54	400,698,945.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			12,977.08	12,977.08
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,846,837.28	16,258,157.55	384,453,764.62	459,558,759.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	6,426,000.00	54,607,065.86		61,033,065.86
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадвал валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайланг үеийн үр дүн			(24,557,841.62)	(24,557,841.62)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,272,837.28	70,865,223.41	359,895,923.00	496,033,983.69

4417144353  
E:CA0056 902570

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЭЭЛИЙН ДҮН	185,750,000.00	184,402,047.80	1,347,952.20	99.27
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	185,750,000.00	184,402,047.80	1,347,952.20	99.27
4	Бараа, үйлчилгээний зардал	163,747,600.00	162,399,647.80	1,347,952.20	99.18
5	Цалин хэсэ болон нэмэгдэл урамшил	108,214,400.00	108,033,927.00	180,473.00	99.83
6	Үндсэн цалин	91,227,400.00	93,149,595.00	(1,922,195.00)	102.11
7	Нэмэгдэл	6,637,000.00	4,810,053.00	1,826,947.00	72.47
8	Ужир, болон бусад нөхөн олговор	2,865,000.00	2,824,600.00	40,400.00	98.59
9	Урамшуулал	7,485,000.00	7,249,679.00	235,321.00	96.86
11	Ажил олгогчоос нийгэмийн даатгалд төлөх шавтгал	14,152,600.00	13,461,441.00	691,159.00	95.12
12	Тэтгэврийн даатгал	9,943,100.00	12,709,434.00	(2,766,334.00)	127.82
13	Тэтгэмжийн даатгал	1,052,400.00	160,502.00	891,898.00	15.23
14	ҮОМШО ний даатгал	841,900.00	177,901.00	663,999.00	21.13
15	Ажилгүйдлийн даатгал	210,400.00	37,600.00	172,800.00	17.87
16	Эрүүл мэндийн даатгал	2,104,800.00	376,004.00	1,728,796.00	17.86
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,164,000.00	12,162,138.00	1,862.00	99.98
18	Гэрэл цахилгаан	2,393,000.00	2,391,138.00	1,862.00	99.92
19	Түлээ, халаалт	6,800,000.00	7,475,000.00	(675,000.00)	109.93
20	Цэвэр, бохир ус	2,971,000.00	2,296,000.00	675,000.00	77.28
22	Хангамж, бараа материалын зардал	6,229,500.00	6,047,890.00	181,610.00	97.08
23	Бичиг хэрэг	80,000.00	394,500.00	(314,500.00)	493.33
24	Тээвэр (шатахуун)	950,000.00	1,235,120.00	(285,120.00)	130.01
25	Шуудан, холбоо, интернетын тоолбор	759,500.00	-	759,500.00	-
26	Нөм, хэвлэл	190,000.00	-	190,000.00	-
28	Бяга үнэтэй, түрсэн эзлэхүүн, аж ахуйн эд зүйлс	4,250,000.00	4,418,270.00	(168,270.00)	103.96
30	Норматив зардал	14,009,900.00	14,008,901.80	998.20	99.99
31	Эм бэлдэж, эмнэлгээний хэрэгсэл	110,000.00	110,000.00	-	100.00
32	Хоол, хунс	12,169,900.00	12,168,901.80	998.20	99.99
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,730,000.00	1,730,000.00	-	100.00
34	Эд хосинг худалдан авалт	3,460,000.00	3,308,850.00	151,150.00	95.63
35	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	440,000.00	-	100.00
36	Тавилга	750,000.00	750,000.00	-	100.00
38	Урсгал засвар	2,270,000.00	2,118,850.00	151,150.00	93.34
39	Томиллолт, зочны зардал	233,300.00	112,000.00	121,300.00	48.01
41	Дотоод албан томиллолт	233,300.00	112,000.00	121,300.00	48.01
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тоолбор	394,500.00	394,500.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тоолбор, хураамж	394,500.00	274,500.00	120,000.00	69.58
45	Аудит, баталгаажуулалт зэрэгтэй тогтоох зардал	-	120,000.00	(120,000.00)	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	4,889,400.00	4,870,000.00	19,400.00	99.60
55	Хөгжөл үйлдвэрлэлийн дэдлага хийх	4,889,400.00	4,870,000.00	19,400.00	99.60
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,002,400.00	22,002,400.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	22,002,400.00	22,002,400.00	-	100.00
76	Тэтгэвэрт гарч адал нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,902,400.00	21,902,400.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	100,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,750,000.00	185,575,006.00	174,994.00	99.91
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,750,000.00	185,575,006.00	174,994.00	99.91
99	Улсын төсвөөс санхүүжих	185,750,000.00	185,575,006.00	174,994.00	99.91
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛИЙН АНГИШАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛАГСДЫН ТОО	-	-	-	-
134	Улирдах ажилтан	-	-	-	-
135	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
136	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО (энийн дундаар)	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

441714435  
EIOA0056 902570